



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбулган сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/022/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Архангай аймаг 2025 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Утас: 7033-3019 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.24 № 42

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА Б.АЗХҮҮ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн сонгууль зохион байгуулагдаж 29 хурлын төлөөлөгч шинээр сонгогдсон байна.

#### Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2024 онд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагаа, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, ИТХ-д суудалтай намуудад олгох дэмжлэг, гэмт гэргээс урьдчилан сэргийлэх гэсэн нийт 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсвөөс 402,836.3 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 356,614.5 мянган төгрөгийг зарцуулж, 46,221.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь төсвийн төлөвлөлтэй холбоотой байна.

#### Бусад асуудлын хэсэг

Эрдэнэбулган сумын ИТХ нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 үндсэн зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 2 арга хэмжээ хэрэгжээгүй, 5 арга хэмжээ 50-60 хувь, 2 арга хэмжээ 70-80 хувь, 9 арга хэмжээ 90 хувь,

10 арга хэмжээг 100 хувь биелүүлж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сумын ИТХ-аас 84.5 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	704,500.00	200,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	704,500.00	200,200.00
354	Хангамжийн материал	704,500.00	200,200.00
3541	Бичиг хэргийн материал	454,500.00	200,200.00
3544	Түлш, шатах тослох материал	250,000.00	-
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	23,041,424.83	21,666,434.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	23,041,424.83	21,666,434.57
392	Биет хөрөнгө	23,041,424.83	21,666,434.57
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,125,000.00	-8,625,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,100,000.00	11,750,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,350,000.00	-3,030,833.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,033,100.00	18,071,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,616,675.17	-11,498,932.10
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	23,745,924.83	21,866,634.57
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
414	Урьдчилж орсон орлого	-	-
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	23,745,924.83	21,866,634.57
51	Засгийн газрын хувь оролцоо	23,745,924.83	21,866,634.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,350,000.00	3,350,000.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		
51101	Өмч: - төрийн	3,350,000.00	3,350,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	20,395,924.83	18,516,634.57
5121	Өмнөх үеийн үр дүн	20,395,924.83	20,395,924.83
5122	Тайлант үеийн үр дүн	-	-1,879,290.26
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	-
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	23,745,924.83	21,866,634.57

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	454,802,300.00	402,836,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	454,802,300.00	402,836,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	600,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	600,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	454,202,300.00	402,836,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	454,202,300.00	402,836,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	452,462,353.68	404,643,590.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	452,462,353.68	404,643,590.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	242,249,252.50	322,517,578.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,946,018.82	168,681,625.44

**Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210101	Үндсэн цалин	82,127,321.13	109,815,060.31
210102	Нэмэгдэл	24,113,035.00	47,924,217.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,460,000.00	10,942,347.16
210104	Урамшуулал	13,245,662.69	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,314,719.00	18,938,112.73
210201	Тэтгэврийн даатгал	11,084,806.00	13,071,922.39
210202	Тэтгэмжийн даатгал	1,292,451.00	1,515,042.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,097,073.00	950,119.62
210204	Ажилгүйдлийн даатгал	255,894.00	370,945.81
210205	Эрүүл мэндийн даатгал	2,584,495.00	3,030,082.48
2104	Хангамж, бараа материалын зардал	5,812,121.00	6,837,310.00
210401	Бичиг хэрэг	1,967,800.00	1,695,950.00
210402	Тээвэр, шатахуун	2,749,999.00	3,240,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	594,322.00	917,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	983,810.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,989,500.00	2,580,500.00
210604	Урсгал засвар	2,989,500.00	2,580,500.00
2107	Томиллолт, зочны зардал	860,000.00	1,230,000.00
210702	Дотоод албан томиллолт	860,000.00	1,230,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,207,190.00	65,081,040.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,154,950.00	65,028,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	47,240.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,240.00	5,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,119,703.68	59,168,990.47
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,035,150.00	53,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,084,553.68	6,168,990.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	210,213,101.18	82,126,011.83
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	33,000,000.00	30,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	33,000,000.00	30,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,919,000.00	5,904,250.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,919,000.00	5,904,250.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	172,294,101.18	46,221,761.83
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	172,294,101.18	46,221,761.83
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,339,946.32	-1,807,290.47
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	71,999.79
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	71,999.79
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-71,999.79
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,339,946.32	-1,879,290.26

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	454,802,300.00	402,836,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	454,802,300.00	402,836,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	600,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	600,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	454,202,300.00	402,836,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	454,202,300.00	402,836,300.00

**Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	446,702,300.00	397,970,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	446,702,300.00	397,970,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	236,489,198.82	315,844,288.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,946,018.82	168,681,625.44
210101	Үндсэн цалин	82,127,321.13	109,815,060.31
210102	Нэмэгдэл	24,113,035.00	47,924,217.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,460,000.00	10,942,347.16
210104	Урамшуулал	13,245,662.69	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,314,719.00	18,938,112.73
210201	Тэтгэврийн даатгал	11,084,806.00	13,071,922.39
210202	Тэтгэмжийн даатгал	1,292,451.00	1,515,042.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,097,073.00	950,119.62
210204	Ажилгүйдлийн даатгал	255,894.00	370,945.81
210205	Эрүүл мэндийн даатгал	2,584,495.00	3,030,082.48
2104	Хангамж, бараа материалын зардал	6,136,621.00	6,333,010.00
210401	Бичиг хэрэг	2,042,300.00	1,441,650.00
210402	Тээвэр, шатахуун	2,999,999.00	2,990,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	594,322.00	917,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	983,810.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,989,500.00	2,580,500.00
210604	Урсгал засвар	2,989,500.00	2,580,500.00
2107	Томилолт, зочны зардал	860,000.00	1,230,000.00
210702	Дотоод албан томилолт	860,000.00	1,230,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,207,190.00	65,081,040.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,154,950.00	65,028,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	47,240.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,240.00	5,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,035,150.00	53,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,035,150.00	53,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	210,213,101.18	82,126,011.83
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	33,000,000.00	30,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	33,000,000.00	30,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,919,000.00	5,904,250.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,919,000.00	5,904,250.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	172,294,101.18	46,221,761.83
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	172,294,101.18	46,221,761.83
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,100,000.00	4,866,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,100,000.00	4,866,000.00
	Дотоод эх үүсвэрээр	8,100,000.00	4,866,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,100,000.00	4,866,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-8,100,000.00	-4,866,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,350,000.00	18,055,978.51	21,405,978.51
7	Тайлант үеийн үр дүн		2,339,946.32	2,339,946.32
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,350,000.00	20,395,924.83	23,745,924.83
15	Тайлант үеийн үр дүн		-1,879,290.26	-1,879,290.26
16	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,350,000.00	18,516,634.57	21,866,634.57

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	402,836,300.00	356,614,538.17	46,221,761.83	88.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	402,836,300.00	351,748,538.17	51,087,761.83	87.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	363,836,300.00	315,844,288.17	47,992,011.83	86.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	192,850,000.00	168,681,625.44	24,168,374.56	87.47
210101	Үндсэн цалин	127,330,000.00	109,815,060.31	17,514,939.69	86.24
210102	Нэмэгдэл	49,470,000.00	47,924,217.97	1,545,782.03	96.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,050,000.00	10,942,347.16	5,107,652.84	68.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,106,300.00	18,938,112.73	5,168,187.27	78.56
210201	Тэтгэврийн даатгал	16,392,300.00	13,071,922.39	3,320,377.61	79.74
210202	Тэтгэмжийн даатгал	1,928,500.00	1,515,042.43	413,457.57	78.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,542,800.00	950,119.62	592,680.38	61.58
210204	Ажилгүйдлийн даатгал	385,700.00	370,945.81	14,754.19	96.17
210205	Эрүүл мэндийн даатгал	3,857,000.00	3,030,082.48	826,917.52	78.56
2104	Хангамж, бараа материалын зардал	8,000,000.00	6,333,010.00	1,666,990.00	79.16
210401	Бичиг хэрэг	3,000,000.00	1,441,650.00	1,558,350.00	48.06
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	2,990,050.00	9,950.00	99.67
210403	төлбөр Шуудан, холбоо, интернэтийн	1,000,000.00	917,500.00	82,500.00	91.75
210406	эд зүйлс Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн	1,000,000.00	983,810.00	16,190.00	98.38
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	7,446,500.00	553,500.00	32.26
210602	Тавилга	5,000,000.00	4,866,000.00	134,000.00	
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,580,500.00	419,500.00	86.02
2107	Томилот, зочны зардал	2,000,000.00	1,230,000.00	770,000.00	61.5
210702	Дотоод албан томилот	2,000,000.00	1,230,000.00	770,000.00	61.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75,880,000.00	65,081,040.00	10,798,960.00	85.77
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	75,500,000.00	65,028,800.00	10,471,200.00	86.13
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	-	300,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	47,240.00	2,760.00	94.48
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000.00	5,000.00	25,000.00	16.67
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,000,000.00	53,000,000.00	-	100
210902	хийх Хичээл үйлдвэрлэлийн дадлага	53,000,000.00	53,000,000.00	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,000,000.00	35,904,250.00	3,095,750.00	92.06
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	31,000,000.00	30,000,000.00	1,000,000.00	96.77
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	31,000,000.00	30,000,000.00	1,000,000.00	96.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,000,000.00	5,904,250.00	2,095,750.00	73.8

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,000,000.00	5,904,250.00	2,095,750.00	73.8
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	402,836,300.00	356,614,538.17	46,221,761.83	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	402,836,300.00	356,614,538.17	46,221,761.83	
132001	Орон нутгийн төсвөөс	402,836,300.00	356,614,538.17	46,221,761.83	
3	Төсвийн байгууллага		1	1	100
5	АЖИЛЛАГСДЫН ТОО		5	5	100
6	Удирдах ажилтан		1	1	100
7	Гүйцэтгэх ажилтан		3	3	100
8	Үйлчлэх ажилтан		1	1	100

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа<sup>1</sup> илрээгүй. Харин залруулаагүй 2,518.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч 478.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2,040.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 2,518.0 мянган төгрөг бөгөөд тооцсон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 4,531.9 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

#### 3.1 Төлбөрийн акт

3.1.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас "Гэмт хэрэг зөрчил, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр видео контент бүтээх уралдаан"-ыг зохион байгуулж, 2,178.0 мянган төгрөгийг байгууллагын нярвын дансаар дамжуулан шагнал болон бусад зардалд зарцуулсан бөгөөд үүнээс 478.0 мянган төгрөгийн зарцуулалт нь анхан шатны баримтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

#### 3.2 Албан шаардлага

5.2.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас томоохон зах худалдааны төвүүдэд хулгайн гэм хэргээс сэрэмжлүүлэх, эд хөрөнгөөрөө хохирохоос сэргийлэх зорилгоор А3 хэмжээтэй 100 ширхэг, А4 хэмжээтэй 200 ширхэг, А5 хэмжээтэй 1000 ширхэг брошур, ухуулах хуудсыг нийт 2,040.0 мянган төгрөгөөр Нью-Гэрэлт ертөнц ХХК-аас худалдан авсныг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн, ухуулах хуудсыг хүн олноор цуглардаг худалдааны төв, дэлгүүр захуудад байршуулсан гэсэн боловч нотлох анхан шатны баримт, ажлын тайлангүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20.2.4-д "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй албан шаардлага хүргүүлэх

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

#### **4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

---

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Анхан шатны баримгүй	1	478.0	1	478.0						
Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй	1	2024.0			1	2040.0				
Дүн	2	2518.0	1	478.0	1	2040.0				